

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

**СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ӨВЧТЭЙ ЭТГЭЭДИЙГ
ЗАХИРГААНЫ ЖУРМААР АЛБАДАН ЭМЧЛЭХ, АЛБАДАН ХӨДӨЛМӨР
ХИЙЛГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсад 1961 оноос эхлэн архинд донтох өвчтэй иргэдийг албадан эмчилж эхэлсэн бөгөөд албадан эмчлэх байгууллага нь 2000 он хүртэл цагдаа, хорих, эрүүл мэндийн байгууллагын харьяанд тус тус ажиллаж байсан байна.

Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль 2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2000 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 148 дугаар тогтоол гарч, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа Багахангай дүүрэг дэх Архинд донтох өвчтөнг албадан эмчлэх эмнэлгийг Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харьяанд шилжүүлж, “Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар” болгон зохион байгуулжээ.

Тус газар нь энэ хугацаанд үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, нийгэмд тулгамдаж буй асуудал болох согтуурах донтой хүнийг албадан эмчлэхэд ахиц гарган ажиллаж байна.

Согтуурах, мансуурах донтой, өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газраас эмчлүүлэгчдийн судалгааг сүүлийн 15 жилээр гаргахад нэг жилд эмчлүүлэгчдийн тоо 290-ээс 1040-ийн хооронд хэлбэлзэж байна.

Согтуурах болон мансуурах донтой болсон хүмүүсийг албадан эмчлэх асуудлыг зохицуулах нь төрийн орхиж болохгүй үүрэг бөгөөд Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулах асуудлыг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлсон.

Хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх ажлын хүрээнд тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын үйл ажиллагааг боловсронгуй болгох, энэ газарт эмчлүүлж байгаа хүний эрх зүйн байдлыг сайжруулахад юуны түрүүнд даган мөрдөж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох зүй ёсны шаардлага тавигдаж байна.

Хуульд тодорхой заагаагүйн улмаас Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа зарим асуудлыг шийдвэрлэх, хуульд заасан боловч хэрэгжих боломжгүй байгаа зарим зохицуулалтыг халах нь зүйтэй байна.

Монгол Улсын нэгдэн орсон холбогдох олон улсын гэрээ конвенци болон сүүлийн үед батлагдан гарсан бусад хуультай энэ хуулийн зүйл, хэсэг, заалт, нэр томъёог нийцүүлэх шаардлага байна.

Хоёр.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц

Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийн цар хүрээг харгалзан хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх гэж нэр томъёог өөрчилнө.

Хуулийн төсөлд согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх үндэслэлийг тодорхой заана.

Тухайн хүнийг албадан эмчилгээнд явуулах хүсэлт гаргахаас эхлээд бүх ажиллагааны явцад хүний эрхийг зөрчихгүй байх нөхцөл бүрдүүлэх үүднээс согтуурах, мансуурах донтой эсэх тухай үзлэг, шинжилгээ хийж, эмнэлгийн дүгнэлт гаргах, албадан эмчлэх шийдвэр гаргах, албадан эмчлэх газарт хүлээж авах талаар илүү нарийвчлан тусгана.

Хуульд албадан эмчлэх мэргэжлийн удирдлагыг эрүүл мэндийн байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан боловч ямар байгууллага яаж хэрэгжүүлэхийг хуульд тусгаагүй учраас энэ асуудал орхигдож ирсэн тул албадан эмчлэх мэргэжлийн удирдлагыг хариуцах байгууллагыг тодорхой болгож, мэргэжлийн удирдлагын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүргийг заана.

Зайлшгүй шаардлагатай зарим зардлын эх үүсвэрийг, тухайлбал эмчлүүлэгчийн суурь өвчнийг оношлох, эмчлэх, хоол, хувцасны болон эмнэлэгт ирэх, буцах замын зардал зэргийг Албадан эмчлэх эмнэлгийн зардалд тооцож оруулахаар заана.

Өнгөрсөн хугацаанд мансуурах донтой хүн эмчлүүлэхээр ирж байгаагүй байх боловч ийм хүнийг эмчилгээнд хамруулах хэрэгцээ байгааг харгалзан мансуурах донтой хүнийг албадан эмчлэх үндэслэлийг хуульд хэвээр үлдээнэ.

Холбогдох олон улсын конвенцид нийцүүлэн албадан хөдөлмөр хийлгэх тухай зохицуулалтыг хасч, сэтгэц, нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээний хүрээнд нөхөн сэргээх хөдөлмөр эмчилгээ хийхээр тусгана.

Хуульд байгууллага, албан хаагчдын хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрх хэмжээний талаар заасан боловч албадан эмчлүүлэгчийн эрх, үүргийн талаар тусгаагүй. Иймээс хуулийн төсөлд албадан эмчлүүлж байгаа хүний эрх, үүргийн тухай зүйл, заалт нэмнэ.

Албадан эмчлэх газарт эмчлүүлээд гарсан хүний асуудлыг хэрхэн анхаарах талаар зохицуулалт нэмнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжүүлэх явцад төсөвт хүндрэл болох нэмэлт хөрөнгө, зардал шаардагдахгүй.

Дөрөв.Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн төсөлтэй уялдан Архидан согтуурахтай тэмцэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай зэрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.

-----oOo-----